

## МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

---



Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын  
Байнгын хорооны саналын дагуу хийсэн  
аудитын тайлан



**Төрийн албаны зөвлөлийн зарим үйл  
ажиллагааны үр нөлөөг сайжруулах  
шаардлагатай байна**

---

Улаанбаатар хот 2007 он

ҮАГ-1/2007/05-ЭА

## Агуулга

### Тайланг бэлтгэсэн:

#### ҮАГ-ын нэгдүгээр газар

Захирал

*Д.Ганбилэгэ*

Аудитын менежер

*Ж.Батсайхан*

Ахлах аудитор

*Г.Нямдорж*

Аудитор

*И.Туяа*

Шинжээч

*Ж.Сарантуяа  
У.Баярмаа*

2007 оны 7 дугаар сар

**Тайланг ҮАГ-ын вэб  
сайтаас үзнэ үү:**

[www.mnao.pmis.gov.mn](http://www.mnao.pmis.gov.mn)

Аудитын тайлантай  
холбоотой асуудлаар нэмж  
тодруулах асууж лавлах  
зүйл байвал 261740 дугаарын  
утас, 323266 дугаарын  
факсаар харилцана уу.

ХАЯГ. Үндэсний аудитын  
газар. Засгийн газрын 4  
дүгээр байр. Бага тойруу-6  
Улаанбаатар-46  
Монгол Улс

### Ерөнхий зүйл

### Хуудас

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй ..... 3  
Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд.....3  
Аудитын стандартын талаархи мэдэгдэл.....3

### Бүлэг 1

Төрийн албан хаагчийн мэргэжлийн шалгалтын  
үр нөлөөг дээшлүүлж, нөөцийн бүртгэлийг  
боловсронгуй болгох шаардлагатай байна .....4

### Бүлэг 2

Төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн,  
мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх ажлын  
биелэлтэд тавих хяналтыг орхигдуулсан байна ...6

### Бүлэг 3

Төрийн албаны зөвлөлд хэрэгжиж байгаа  
төслүүдийн үр дүн, түүний гүйцэтгэлд  
тавих хяналт хангалтгүй байна .....7

### Бүлэг 4

Төрийн жинхэнэ албан хаагчийн томилгоонд  
ТАЗ-ийн гүйцэтгэх үүрэг, оролцоо хангалтгүй  
байна.....10

Дүгнэлт..... 14

Зөвлөмж.....15

Хавсралт.....16

Холбогдох байгууллагын санал.....18

ТАЗ-ийн саналд өгөх тайлбар..... 22

---

## Товчилсон үгс

---

УИХ	Улсын Их Хурал
ЗГ	Засгийн газар
ТАЗ	Төрийн албаны зөвлөл
ҮХЦ	Үндсэн хуулийн цэц
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
ҮЦХ	Үнэт цаасны хороо
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
ҮСГ	Үндэсний статистикийн газар
ҮАБЗ	Үндэсний аюулгүй байдлын зөвлөл
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХЭҮК	Хүний эрхийн үндэсний комисс
ЗТАЖЯ	Зам, тээвэр, аялал жуулчлалын яам
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ТЭХЯ	Түлш, эрчим хүчний яам
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
БХЯ	Батлан хамгаалах яам
БОЯ	Байгаль орчны яам
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
ҮХЯ	Үйлдвэр, худалдааны яам
НХХЯ	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам
ТЕГ	Тагнуулын ерөнхий газар
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
УГЕГ	Улсын гаалийн ерөнхий газар
ХХЕГ	Хил хамгаалах ерөнхий газар
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
ГХЕГ	Гамшгаас хамгаалах ерөнхий газар
ШБӨХЗГ	Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах газар
УМХГ	Улсын мэргэжлийн хяналтын газар
ИНЕГ	Иргэний нисэхийн ерөнхий газар
АМГТХЭГ	Ашигт малтмал, газрын тосны Хэрэг эрхлэх газар
ХХҮГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
УЕПГ	Улсын ерөнхий прокурорын газар
ЗХЖШ	Зэвсэгт хүчний жанжин штаб
АХБ	Азийн хөгжлийн банк
ДБ	Дэлхийн банк
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТБУСТХ	Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль

---

## Ерөнхий зүйл

---

### Аудитын зорилт, хамарсан хүрээ

УИХ-ын Төрийн байгуулалтын Байнгын хорооны санал, Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2007 онд нийлүүлэх бүтээгдэхүүн ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу ТАЗ-ийн 2005-2006 оны үйл ажиллагаанд гүйцэтгэлийн аудит хийлээ.

Дараахь асуудлыг шалгаж дүгнэлт, зөвлөмж гарган холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн. Үүнд:

- Төрийн албан хаагчийн мэргэшлийн шалгалтын үр нөлөө, нөөцийн бүртгэл
- Төрийн албан хаагчийн үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэхэд ТАЗ-ийн гүйцэтгэх үүрэг, оролцоо
- ТАЗ-д хэрэгждэг төслүүдийн санхүүжилт, төрийн албан хаагчдын оролцоо
- Төрийн жинхэнэ албан хаагчдын томилолтод ТАЗ-ийн гүйцэтгэж буй үүрэг, оролцоо

### Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд

- Төрийн албаны тухай хууль
- Төрийн албаны мэргэжлийн шалгалт авах болзол, журам
- Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам
- Холбогдох бусад журам

### Аудитын стандартын талаархи мэдэгдэл

Аудитын явцад асуудлыг шинжлэх, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, тайлбар мэдээ гаргуулах, санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг судлах, нөхцөл байдлын шинжилгээ хийх зэрэг гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглалаа.

Гүйцэтгэлийн аудитыг хийхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, гүйцэтгэлийн шалгалтын журам, Гүйцэтгэлийн аудитын гарын авлага, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгон аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт зөвлөмж боловсруулав.

## Бүлэг 1

### Төрийн албан хаагчийн мэргэжлийн шалгалтын үр нөлөөг дээшлүүлж, нөөцийн бүртгэлийг боловсронгуй болгох шаардлагатай байна

Төрийн албаны тухай хуулийн 7.1, ТАЗ-ийн 2004 оны 36 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны мэргэжлийн шалгалт авах болзол, журам”-ын дагуу

- УИХ, Ерөнхийлөгч, ЗГ, Шүүх, ҮХЦ, СЕХ, Монгол банк, ҮЦХ, ҮСГ, ҮАБЗ, ХЭҮК, Яам, Агентлаг, ТАЗ, Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын болон Засаг даргын ажлын алба, УЕПГ, ЗХЖШ, ТЕГ, ЦЕГ, ГЕГ, ХХЕГ, ШШГЕГ, ГХЕГ-ын төрийн захиргааны гүйцэтгэх болон туслах албан тушаалд анх орох иргэнээс авах мэргэжлийн шалгалтыг Төрийн албаны зөвлөл
- УЕПГ, ЗХЖШ, ТЕГ, ЦЕГ, ГЕГ, ХХЕГ, ШШГЕГ, ГХЕГ зэрэг байгууллагуудад төрийн тусгай албаны гүйцэтгэх болон туслах албан тушаалд иргэнийг анх авах тохиолдолд сонгон шалгаруулалтыг тухайн байгууллага өөрөө
- Монгол банк, ҮЦХ, ҮСГ-ын харьяа орон нутгийн байгууллагуудын төрийн захиргааны болон тусгай албаны гүйцэтгэх болон туслах албан тушаалд анх орох иргэнээс авах шалгалтыг аймаг, нийслэл дэх төрийн албаны салбар комисс зохион байгуулж байна.

2005 онд төрийн захиргааны гүйцэтгэх болон туслах ажилтан 7667 байгаагаас 1996 оноос хойш 6553 хүн төрийн албаны шалгалт өгч ажиллах болсон нь үүний 85.5 хувь болж байна.

ТАЗ нь төрийн жинхэнэ албанд анх орох иргэнээс мэргэжлийн шалгалт авах ажлыг 2005 ,2006 онд тус бүр 2 удаа зохион байгуулжээ.

Төрийн захиргааны төв байгууллагуудаас 2005 онд ирүүлсэн 194 ажлын байрны захиалгын дагуу төрийн албаны шалгалт өгөхөөр 745 хүн бүртгүүлснээс 437 хүн буюу 58.6 хувь, 2006 онд 197 орон тооны төлөө 897 иргэн өрсөлдөж 147 буюу 16.4 хувь, нийслэлийн хэмжээнд 98 ажлын байрны төлөө 772 иргэн өрсөлдөж 56 буюу 7.3 хувь, аймаг, сумын төрийн жинхэнэ албан тушаалын 475 ажлын байрны төлөө 1370 иргэн шалгалтад орж 551 буюу 40.2 хувь нь тэнцжээ.

Нөөцийн жагсаалтад оруулах тухай Төрийн албаны зөвлөлийн шийдвэр 2 жилийн хугацаанд хүчин төгөлдөр байх журмын дагуу 1996 оноос хойш нөөцөд бүртгэгдсэн иргэдээс жилд дунджаар 500 гаруй хүн буюу нийт 5349 хүн төрийн албаны шалгалтад тэнцсэн атлаа томилогдож чадалгүй нөөцийн бүртгэлээс хасагдсан байна.

Нөөцийн бүртгэлээс жил тутам олон зуун хүн хасагдаж байхад 2001-2005 онд 182-1096 хүнийг нөөцөд шинээр бүртгэжээ. Төрийн албаны шалгалтад тэнцсэн иргэдээс зөвхөн зарлагдсан орон тоонд сонгон шалгаруулалтыг явуулж, нэг түвшний шаардлага тавигдах албан тушаал, мэргэжлийн бусад орон тоонд сонгогдох эрхгүй байгаа нь нөөцөд бүртгэгдсэн иргэдийн төрийн албанд ажиллах боломжийг хязгаарлаж байна.

Төрийн байгууллагуудаас ирүүлсэн захиалгад тулгуурлан шалгалтын тестийг 8 төрлийн сорилт тус бүрээр 2 хуваариар бэлтгэж, шалгалтын дүнг тусгай зориулалтын машинаар гаргасан нь үр дүнтэй болжээ. Тестээр шалгалт авахын зэрэгцээ ярилцлага хийж байгаа боловч эдгээр шалгалтаар төрийн албан хэргийг хөтлөж боловсруулах чадвар дүгнэгдэхгүй байна.

Шалгалтын тестийн чанар хангалтгүйгээс шалгалт өгсөн иргэдийн 50-аас дээш хувь нь тэнцдэг ба ШБӨХЗГ, ЗТАЖЯ, ТЭХЯ-нд ажиллахаар шалгалт өгсөн иргэдийн 70.2-78.0 хувь нь тэнцэж байжээ. Мөн тестийн асуудлуудыг тухайн салбарын мэргэжлийн асуултууд 30 хувь, төрийн албаны холбогдолтой хууль эрхийн актын асуултууд 70 хувь байхаар боловсруулсан нь тухайн салбарын асуудлаар төрийн бодлого үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжүүлэх захиалагч байгууллагын шаардлагыг хангахгүйд хүрч 2001-2005 онд шалгалтад тэнцсэн иргэдийн 484-1553 буюу 34.7-78 хувь нь ажилд томилогдож чадаагүй байна.

Төрийн албаны тухай хуулийн Төрийн албаны зөвлөлийн бүрэн эрхийн тухай 35 дугаар зүйлд “ . . . төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх ажлыг арга зүй, зохион байгуулалтын удирдлагаар хангах”, ТБУСТХ-ийн 47.1-д “Төрийн албаны төв байгууллага нь төсвийн ерөнхийлөн захирагч холбогдох удирдах албан тушаалтантай, ерөнхий менежер төсвийн байгууллагын албан хаагчтай үр дүнгийн гэрээ байгуулж, түүнийг дүгнэх заавар, журмыг баталж биелэлтэд нь хяналт тавина” гэж заажээ.

Үүний дагуу ТАЗ-ийн 2003 оны 6 дугаар тогтоолоор “Төсвийн ерөнхийлөн захирагч менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээг дүгнэх журам”, 7 дугаар тогтоолоор Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшин, төрийн үйлчилгээний албан хаагчийн үр дүнгийн гэрээг үнэлж, дүгнэх журам”-ыг баталж мөрдүүлсэн боловч, төрийн жинхэнэ албан хаагчдын үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх, түүнийг үндэслэн албан тушаал дэвшүүлэх, цол, зэрэг дэв олгох, цалин хөлсийг өөрчлөх, шагнаж урамшуулах, зохих шатны сургалтад хамруулах, албан тушаал бууруулах ажил зохих ёсоор хийгдэж байгаа эсэхэд хяналт тавих ажлыг орхигдуулжээ.

АХБ-ны олон улсын зөвлөх Жанет Тей төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үнэлгээний дүнгийн 70 хувь нь маш сайн ба сайн, хангалттай, 30 хувь нь дутагдалтай ба хангалтгүй байвал бодит байдалд нийцсэн харьцаа гэж зөвлөсөн боловч 2005 онд үнэлгээнд хамрагдсан төрийн албан хаагчдын 97.6 хувь нь маш сайн, сайн буюу хангалттай, 2.4 хувь нь дутагдалтай, хангалтгүй үнэлгээ авсан байна.

Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв авсан төрийн албан хаагчийн судалгаанаас үзвэл тэргүүн түшмэлийн 45.8 хувь, эрхэлсэн түшмэлийн 55.9 хувь, ахлах түшмэлийн 49.8 хувь зэрэг дэвгүй байна.

Төрийн албаны зөвлөлд төрийн албан хаагчдаас ирүүлж буй гомдол маргааны тоо 2005 онд урьд оноос 100-аар нэмэгдсэний 84 нь үндэслэлгүй халагдсан тухай ба 2006 онд төрийн албаны удирдах албан тушаалтан 12 хүн үндэслэлгүй халагдсан нь ТАЗ-ийн тогтоолоор тогтоогдсон боловч дийлэнх нь ажилдаа буцаан томилогдоогүй нь ирүүлсэн гомдлын мөрөөр дорвитой арга хэмжээ авч чадахгүй байгааг харуулж байна.


ТАЗ үр дүнгийн гэрээ байгуулах, дүгнэх ажлыг боловсронгуй болгох зорилгоор ажил дүгнэх журмын шинэчилсэн төслийг 77 байгууллагад хүргүүлэн, саналыг нэгтгэн шийдвэрлэхээр бэлтгэж байна.

## Бүлэг 3

### Төрийн албаны зөвлөлд хэрэгжиж байгаа төслүүдийн үр дүн, түүний гүйцэтгэлд тавих хяналт хангалтгүй байна

ТАЗ-өөс 2005-2006 онд хэрэгжих төсөл, хөтөлбөрүүдийн ажлын төлөвлөгөөг гарган, ТАЗ-ийн дарга Ж.Норовсамбуу баталж, төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг ажлын албаны дарга Ц. Самбалхүндэв, референт Х. Шаандар, Р.Очбадрах, Д. Энхцэцэг, Д. Нямсүрэн нар хариуцан гүйцэтгэжээ. /Хавсралт 1/

2005-2006 онд доорх чиглэлээр зарцуулагдахаар төлөвлөгдсөн нийт 6,411,337.80 ам.долларын өртөг бүхий 9 төсөл, хөтөлбөрөөс 6 нь хэрэгжиж дууссан байна.



Дээрх төслүүд дараахь зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн байна.

- Төрийн албаны удирдлага, санхүүжилт, зохицуулалт болон хариуцлагыг шинэчлэн бэхжүүлэх /ДБ-Эдийн засгийн чадавхийг бэхжүүлэх төсөл /
- Төрийн албаны хүний нөөцийн зардлын удирдлагыг сайжруулах /ДБ-Засаглалыг дэмжих төсөл/
- Төрийн албаны гүйцэтгэлийн талаар хэрэглэгчийн дунд санал асуулга явуулах, түүний дүнг нийтэлж байх / НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр /
- Ерөнхий менежер болон төрийн жинхэнэ албаны бусад удирдах албан тушаалд томилогдсон хүмүүсийн манлайлах ур чадварыг хөгжүүлэх / Швед-СИДА /
- Цалингийн сан, орон тооны нөхөн хангалтыг бүрдүүлэх замаар төсвийн зарлагын удирдлагыг сайжруулах / ДБ- IDF GRANT /
- Төрийн албан хаагчдын мэдээллийн нэгдсэн сүлжээг байгуулах, тус сүлжээнд хамрагдаж буй хэрэглэгчдийг төрийн алба, төрийн албан хаагчтай холбогдсон мэдээллээр хангах /АХБ-Төрийн Захиргааны Шинэтгэлийн төсөл/
- Ажлын байрны дүн шинжилгээ ба үнэлгээ болон ажлын түвшний стандартыг боловсруулах / Австрали- CABSFAF /
- Удирдах ажилтны манлайлах ур чадварыг дээшлүүлэх сургалт арга зүйн материалыг Монгол улсын эрэлт хэрэгцээнд нийцүүлэн боловсруулах / Швед- СИДА /

ТАЗ-ийн 2005, 2006 онд дэвшүүлсэн стратегийн зорилт, нийлүүлсэн бүтээгдэхүүнд гадны төсөл, хөтөлбөрийн оролцоо дараахь байдалтай байна.



Стратегийн зорилт буюу бүтээгдэхүүний анги	Тухайн жилд нийлүүлсэн бүтээгдэхүүн					
	2005 он			2006 он		
	Нийт тоо	Үүнээс		Нийт тоо	Үүнээс	
төсөлтэй холбоотой		хувь	төсөлтэй холбоотой		хувь	
Төрийн захиргаа, төрийн албаны шинэтгэлийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах	20	2	10.0	14	5	35.7
Төрийн байгууллагыг өөрчлөн хөгжүүлж бизнесийн чадавхийг сайжруулах үйл ажиллагаа	17	2	11.7	18	2	11.1
Төсвийн байгууллагыг өөрчлөн хөгжүүлж, бизнесийн чадавхийг бэхжүүлэх /байгууллагын хөгжил/	11	-	-	10	4	40.0
Төрийн албан хаагчийн мэдлэг чадварыг дээшлүүлэх	10	3	30.0	10	3	30.0
Төсвийн байгууллагын удирдах ажилтны манлайлах үр чадварыг дээшлүүлэх	15	4	26.6	13	4	30.8
Төрийн алба, төрийн албан хаагчтай холбогдсон мэдээллийн технологийг хөгжүүлэх	13	6	46.1	14	7	50.0
<b>ДҮН</b>	<b>86</b>	<b>17</b>	<b>19.8</b>	<b>79</b>	<b>25</b>	<b>31.7</b>

ТАЗ-ийн референт, шинжээчдийн 45.4 хувь гадны төсөл, хөтөлбөрийн ажлыг үндсэн ажилтай зэрэгцүүлж хийдэг бөгөөд тэдний 2005 онд нийлүүлсэн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний 19,2-77,8 хувь, 2006 онд нийлүүлсэн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний 13,0-37,5 хувийг төсөл, хөтөлбөрийн ажил эзэлж байна.

*ТАЗ-д хэрэгжсэн төсөл хөтөлбөрүүдийн зорилтын гол үр дүнг дараахь байдлаар тодорхойлжээ:*

- Нийгмийн аудитын арга зүйг төрийн албаны бүх шатны байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлснээр төсвийн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх менежментийн шинэ аргыг хэрэгжүүлсэн. / НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр /
- Төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан Засгийн газарт өргөн мэдүүлсэн. / ДБ-IDF-GRANT /
- Төрийн албан хаагчдын бүртгэлийн мэдээллийн санг 2005 оноос бий болгон “Интерактив” ХХК-ийн боловсруулсан програм хангамжаар хүний нөөцийн судалгаа, тайланг нийт 200 гаруй үзүүлэлтээр боловсруулдаг болсон. / АХБ /
- Ажлын байрны шинжилгээ, тодорхойлолт, үнэлгээ хийх шинэ арга зүйг эзэмшсэн. / Австрали-CABSAF/

Гадаадын зээл тусламжийг зохицуулах тухай хууль, Сангийн сайдын 2006 оны 447 дугаар тушаалаар батлагдсан “Гадаадын зээл тусламжийн бүртгэл, нэгдсэн мэдээллийн сан байгуулах, ашиглах журам”-ыг баримталж ажиллаагүйгээс ТАЗ-д хэрэгжиж буй төслүүдээс Сангийн яамны Зээл тусламжийн бодлого, зохицуулалтын газрын нэгдсэн бүртгэлд 4 төсөл бүртгэгдээгүй, Засгийн газрын 2006 оны санхүүгийн нэгдсэн тайланд 7 төслийг нэгтгүүлээгүй байна.

Төсөл, хөтөлбөрүүдийн зорилтын биелэлт, үр дүн, бүртгэл, тайлагнал хангалтгүй, гүйцэтгэгчтэй хийсэн гэрээний биелэлтэд тавих хяналт сул байна. Тухайлбал хэрэгжиж дууссан нийт 1,636.3 мянган ам.долларын өртөг бүхий 4 төслийн, хэрэгжиж байгаа 1,280.7 ам. долларын өртөг бүхий 4 төслийн хөрөнгийн зарцуулалтын тайлан, санхүүгийн баримтууд байхгүй учир эдгээр хөрөнгө хэрхэн зарцуулагдсан нь тодорхойгүй байна.

ДБ, АХБ-ны зээлээр санхүүжсэн Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн системийг бий болгох, Төрийн албаны мэдээллийн сүлжээ байгуулах, Австралийн Залуу элч хөтөлбөрийн шугамаар хэрэгжиж буй ТАЗ-ийн мэдээллийн технологийг боловсронгуй болгох төслүүд зорилт, агуулга ижил төстэй, зөвлөх үйлчилгээний зардал нийт санхүүжилтийн 52,3 хувь байгааг анхаарч зээл тусламжийн хөрөнгийн ашиглалтыг сайжруулах шаардлагатай байна.

ТАЗ хэрэгжиж дууссан 4 төсөл, хөтөлбөрийн санхүүжилтээр 46 нэр төрлийн 305,777.84 ам.долларын тоног төхөөрөмж, техник хэрэгсэл худалдан авсан боловч данс бүртгэлд тусгаагүйн гадна эдгээр хөрөнгийн ашиглалт хангалтгүй байна. Тухайлбал, нэг референт 4 нотбук, 3 ширээний компьютер эзэмшиж байгаагаас гадна Desktop компьютер 4 ширхэг, компьютер Dell Optiplex 210IA 1 ширхэг, принтер HP Laserjet 3052, 2420 тус бүр 1 ширхэг, хувилагч Canon 1 ширхэг, нийт 12,674.82 ам.долларын техник хэрэгсэл агуулахад ашиглалтгүй хадгалагдаж байна.

Төрийн албаны мэдээллийн сүлжээг байгуулах төсөл 2005 оны 6 дугаар сард дууссан боловч техник хэрэгсэл нийлүүлсэн М-Си-ЭС Электроникс ХХК-тай албан ёсоор хүлээлцсэн акт баримт үйлдээгүй байна.

ТАЗ “Интерактив” ХХК-тай хийсэн “Төрийн албаны мэдээллийн сүлжээний программ хангамж боловсруулах, портал сайт байгуулах ажил гүйцэтгэх гэрээ”-г дүгнэж, ажлыг хүлээж аваагүй байна. Програм хангамж нь интернетийн орчинд, веб сервер нь нууцлал, вирус хамгаалалтын өндөр түвшинд ажиллах байсан хэдий ч төрийн холбооны 26 дугаартай телефон сүлжээ ашигласан, байгууллагуудын ердийн компьютер дээр суулгасан, ажилтнуудынх нь мэдлэг чадвар дутагдах зэргээс шалтгаалан сүлжээнд доголдол гарч өөрсдөө ТАЗ-д ирж мэдээллээ нэгдсэн санд оруулж байна.

Төрийн албан хаагчийн 2006 оны мэдээ судалгааг гаргуулж нэгтгэх ажил хангалтгүйгээс 2007 оны 5 дугаар сарын 20-ны байдлаар төрийн албан хаагчийн 77.2 хувь, байгууллагын 13.4 хувь бүрэн нэгтгэгдээгүй, мэдээ судалгааг огт ирүүлээгүй 23, мэдээлэл ирсэн боловч бүрэн нэгтгэгдээгүй 657 байгууллага байна.

Төрийн албаны тухай хуулийн “Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх, төрийн жинхэнэ албан тушаалд авах” тухай 17 дугаар зүйл, УИХ-ын 2003 оны 13 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам” –ыг баримтлан иргэдийг төрийн албанд сонгон шалгаруулж байна.

Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллагад ажиллаж байгаа буюу төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчаас үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингээр нь сонгон шалгаруулах замаар уг орон тоог нөхөх ба ингэж нөхөх боломжгүй бол төрийн албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн иргэдээс уг албан тушаалд тавих шаардлагыг үндэслэн шалгаруулдаг байна.

“Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам” –д “төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд төрийн захиргааны болон төрийн тусгай албаны зорилт, чиг үүргийг хэрэгжүүлдэг төрийн байгууллагын зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга түүнээс дээшхи бусад албан тушаал хамаарна” гэж заажээ.

Төрийн байгууллагуудаас 1996-2006 онд ирүүлсэн сул ажлын байрны захиалгын 30.3 хувьд буюу шалгалтад тэнцэж нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн 3.2 мянган иргэн нөөцөөс хасагдсан байна.


“Төрийн албаны мэргэжлийн шалгалт авах болзол, журам”-ын 4.1.2-ын “. . . нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн иргэдээс уг албан тушаалд тавигдах шаардлагыг харгалзан сонгон шалгаруулж тухайн орон тоог нөхнө”, 4.1.5-ын “. . . иргэнийг түр томилон ажиллуулсан байгууллага, . . . хамгийн өндөр оноо авч. . . шалгалтын. . . комиссоос санал болгосон 3 иргэнээс сонголт хийж уг албан тушаалд томилно” гэсэн заалтуудыг зөрчин дараахь байгууллагууд шалгалт өгч тэнцсэн иргэдээс төрийн албанд томилоогүй байна.

Байгууллагын нэр	Захиалга өгсөн ажлын байрны тоо	Хүний тоо	
		Шалгалт өгч тэнцсэн	Төрийн албаны ажилд орсон
УИХ-ын Тамгын Газар	2	4	
ҮСГ	3	3	1
Алтанбулаг ХЧБ-ийн захирагчийн ажлын алба	13	15	5
НХХЯ	5	20	3
БСШУЯ	5	11	2
УМХГ	11	40	7
СЗХ	15	9	6

Төрийн албаны тухай хуулийн 17.12-т “Төрийн байгууллага нь албан ажлын зайлшгүй шаардлагыг үндэслэн төрийн захиргааны албан тушаалд иргэнийг 6 сар хүртэл хугацаагаар түр томилж болно” гэж заасан нь төрийн албаны шалгалтад оролгүйгээр төрийн захиргааны албан тушаалд түр томилогдоход ихээхэн нөлөөлж

байгаа ба 2006 оны 11 дүгээр сарын 10-ны байдлаар яамдын төрийн нарийн бичгийн дарга, газар, агентлагийн дарга 27 хүн түр томилгоотой ажиллаж байжээ.

Төрийн албаны удирдах албан тушаалтныг сонгон шалгаруулж 3-5 хүний нэрийг дэвшүүлэн түүнийг томилох эрх бүхий этгээдэд санал болгох үүргийг ТАЗ хүлээдэг байна. Дараахь зурагт удирдах албан тушаалтныг сонгон шалгаруулах үйл ажиллагааг үзүүлжээ.



Төрийн албанд анх орсон хүнийг анхан буюу доод шатны албан тушаалаас эхлэн албан тушаалд дэвшүүлэх замаар өсгөж хөгжүүлдэг карьерийн тогтолцооны үндсэн зарчмуудыг Төрийн албаны тухай хуульд тусгаж өгсөн байдаг.

2004-2006 онд төрийн албаны удирдах 167 ажилтны сонгон шалгаруулалтад 574 иргэн оролцож, 91.6 хувь буюу 526 иргэн тэнцэн нөөцөд бүртгэгдсэнээс үзвэл удирдах ур чадварын түвшинг шалгах тест, ярилцлагад тавигдах шаардлагыг өндөржүүлэх нь зүйтэй байна.

Холбогдох хууль тогтоомжийг зөрчин төсвийн, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 76 аж ахуйн нэгж байгууллага сонгон шалгаруулалтад өрсөлдөөгүй 389 иргэнийг удирдах албан тушаалд томилсон байна.

Гэтэл дээрх зарчмууд болон Төрийн албаны тухай хуулийн 17.5-ын “Хуульд өөрөөр заагаагүй бол ажил олгогч төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тооны талаар нийтэд мэдээлэх үүрэгтэй” гэсэн заалтыг зөрчиж, төрийн албаны удирдах албан тушаалтныг сонгон шалгаруулалтгүйгээр томилж байна. Тухайлбал, 2005 онд ТЭХЯ, ХЗДХЯ -ны Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга, ЗТАЖЯ-ны Төрийн нарийн

бичгийн дарга, ИНЕГ-ын дарга, дэд дарга, ШБӨХЗГ-ын дэд дарга болон зохион байгуулалтын нэгжийн дарга, 2006 онд УГЕГ-ын дарга, дэд дарга, НХХЯ-ны газрын дарга, СЕХ-ны Ажлын албаны дарга, Үндэсний архивын газрын дэд дарга зэрэг 2005 онд 25, 2006 онд 22 төрийн албаны удирдах ажилтан сонгон шалгаруулалтад оролгүй томилогджээ. Төрийн албаны удирдах ажилтны сонгон шалгаруулалт хийгдсэн байдлыг харуулбал:

Үзүүлэлт	Хүний тоо	
	2005 он	2006 он
Ирсэн захиалга	89	31
Шалгаруулалтад тэнцсэн	266	106
Нэр дэвшигчээс томилогдсон	86	25
Нөөцөөс сонгогдсон	0	1
Нөөцөөс сонгоггүй дахин шалгаруулалт хийсэн	1	4
Маргааныг хянан шийдвэрлэж үндэслэлийг хянасан	10	9
Гомдол гаргалгүй халагдсан	5	3
Шалгаруулалтад ороогүй томилогдсон	25	22

Төрийн албан тушаалд анх орох иргэд болон төрийн албаны удирдах албан тушаалд өрсөлдөх иргэдийг бүртгэхэд тавигдах шаардлага адил байгаа нь төрийн албаны удирдлагыг чадварлаг ажилтнаар бэхжүүлэх зорилтод нийцэхгүй байна.

Төрийн албаны удирдах албан тушаалд сонгон шалгаруулахад оролцогч иргэдийг бүртгэхэд тавигдах шаардлага нь захиалагч талаас ирүүлсэн ажлын байрны тодорхойлолт байдгаас ажлын байрны тодорхойлолтыг салбар бүр өөрөөр, мөн тухайн албан тушаалд томилох иргэндээ тохируулах явдал гарч байна.

Тухайлбал, Төрийн нарийн бичгийн даргын ажлын байрны тодорхойлолтоор тавигдах шаардлагыг ЭМЯ докторын зэрэгтэй, төрийн албанд 10-аас дээш жил, салбарын удирдах албан тушаалд 5-аас дээш жил ажилласан, гадаад хэлний зохих түвшний мэдлэгтэй байхаар, ХЗДХЯ наад зах нь орос, англи хэлтэй байхаар, БХЯ магистраас доошгүй зэрэгтэй, төрийн албанд 15-аас дээш жил, цэргийн мэргэжлийн төв байгууллагад 3-аас дээш жил ажилласан, орос, англи хэлний мэдлэгтэй байхаар, ЗТАЖЯ магистраас доошгүй зэрэгтэй, төрийн болон бизнесийн байгууллагад 5-аас доошгүй жил, үүнээс 3-аас доошгүй жилд нь удирдах албан тушаалд ажилласан, орос англи хэлээр сайн ойлгож ярьж бичиж чаддаг байхаар, БОЯ докторын зэрэгтэй, төрийн албанд 10 хүртэл, үүнээс хэлтсийн даргаас дээш албан тушаалд 3-аас дээш жил ажилласан байхаар тус тус тогтоожээ.

УИХ-ын 1995 оны 73 дугаар тогтоолд тэргүүн түшмэлийн ангилалд буй төрийн нарийн бичгийн даргын албан тушаалтан төрд 12 жилээс доошгүй жил ажилласан байхаар заасан атал ажлын байрны шаардлагыг төрийн алба болон бизнесийн салбарт 3-5 жил ажилласан байхаар томилогдсон хүндээ тохируулан боловсруулж, ЗТАЖЯ-ны төрийн нарийн бичгийн дарга Ц.Бат-Энхийг 2006 онд сонгон шалгаруулалтгүй хууль зөрчиж томилжээ.

ТАЗ-өөс БХБЯ-ны Төрийн нарийн бичгийн даргад нэр дэвшүүлсэн 3 хүнээс сонгоггүй 2006 онд Ц.Ганхүүг, ҮХЯ-ны АМГТХЭГ-ын 1 дүгээр орлогч даргад нэр дэвшүүлсэн 3 хүнээс сонгоггүй Ц.Ганхуягийг, НХХЯ-ны Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын даргаар эхэлж нэр дэвшсэн 7 хүнээс сонгоггүй шинээр нэр дэвшигдсэн 5 хүнээс Д.Баярсайхан нарыг тус тус томилжээ.

Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд эхний ээлжинд тухайн байгууллагад ажиллаж байгаа буюу төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа албан хаагчаас болон нөөцөд буй иргэдээс 2-оос доошгүй хүнийг сонгон шалгаруулж, орон тоог нөхөхөөр заасан атал томилогдсон ажилтнууд тухайн байгууллагад ажиллаж байгаагүй, нөөцөд өмнө нь бүртгэгдээгүй байгаа нь төрийн албаны хуульд тусгагдсан карьерийн тогтолцооны зарчмыг алдагдуулж байна.

## Дүгнэлт

Аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт гаргаж байна. Үүнд:

1. Төрийн албан хаагчийн мэргэжлийн шалгалтын үр нөлөөг дээшлүүлж, нөөцийн бүртгэлийг боловсронгуй болгох шаардлагатай байна
2. Төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх ажлын биелэлтэд тавих хяналтыг орхигдуулсан байна
3. Төрийн албаны зөвлөлд хэрэгжиж байгаа төслүүдийн үр дүн, түүний гүйцэтгэлд тавих хяналт хангалтгүй байна
4. Төрийн жинхэнэ албан хаагчийн томилгоонд ТАЗ-ийн гүйцэтгэх үүрэг, оролцоо хангалтгүй байна

**Зөвлөмж**

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Төрийн албаны зөвлөлийн дарга Ж.Норовсамбууд зөвлөж байна:

- Төрийн албаны тухай хуульд ТАЗ-ийн чиг үүргийг оновчтой болгох, бүрэн эрхийг өргөжүүлэх чиглэлээр холбогдох нэмэлт өөрчлөлт оруулах саналыг зохих журмын дагуу боловсруулж шийдвэрлүүлэх
- “Төрийн албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам, мэргэжлийн шалгалт авах болзол, журам”, “Төрийн албаны мэргэжлийн шалгалт авах болзол, журам”-ын хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах
- “Гадаадын зээл, тусламжийг зохицуулах тухай хууль”, Сангийн сайдын 2006 оны 447 дугаар тушаалаар батлагдсан “Гадаадын зээл тусламжийн бүртгэл, нэгдсэн мэдээллийн сан байгуулах, ашиглах журам”-ыг мөрдөж, зорилт, агуулгаараа ижил төстэй, үр өгөөж багатай төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхгүй байх
- 2005-2006 онд хэрэгжиж дууссан төсөл, хөтөлбөрүүдийн дагуу нийлүүлсэн техник, тоног төхөөрөмжүүдийг нягтлан бодох бүртгэлд тусгах, “Интерактив” ХХК-тай байгуулсан гэрээний биелэлтийг тооцож дүгнэх
- Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэжлийн түвшин, төсвийн ерөнхийлөн захирагч, ерөнхий менежер, төрийн үйлчилгээний албан хаагчийн үр дүнгийн гэрээ байгуулах, дүгнэх ажлын чанарт тавих хяналтыг дээшлүүлэх
- Төрийн албаны мэргэжлийн шалгалтын асуултын бүтцэд мэргэшлийн мэдлэгийн асуултуудын эзлэх хувийн жинг нэмэгдүүлэх боломжийг судалж шийдвэрлэх
- Төрийн албаны мэргэжлийн шалгалтад тэнцэх босго оноог дээшлүүлэх, адил түвшний шаардлага тавигдах албан тушаал, мэргэжлийн бусад орон тоонд сонгогдох эрхийг төрийн жинхэнэ албан тушаалд орох нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн иргэдэд олгох асуудлыг судалж шийдвэрлэх



## 2005-2006 онуудад ТАЗөвлөлд хэрэгжсэн болон хэрэгжиж байгаа гадаадын зээл, тусламжийн судалгаа

/ам.доллараар/

д/д	Зээл тусламжийн санхүүжүүлэгч	Төслийн нэр, хэрэгжих хугацаа	Нийт санхүүжилт							ТАЗөвлөлөөс хариуцах эзэн
			Зээлийн хөрөнгөөр	Буцалтгүй тусламжаар	Үүнээс					
					Зөвлөх үйлчилгээ	Сургалт, семинар	Танилцах аялал	Бараа бүтээгдэхүүн	Бусад	
1	Дэлхийн банк	Эдийн засгийн чадавхийг бэхжүүлэх техник туслалцааны төсөл 2004/02/11-2007/09/30	3,108,560.00		1,532,060,00	56,500,00		1,520,000,00		Р.Очбадрах ТАЗ-ийн ажлын алба
2	Дэлхийн банк	Засаглалыг дэмжих төсөл 2006/07/21-2012		385,700,00	247,100.00	65,000,00	40,000,00	33,600,00		Р.Очбадрах ТАЗ-ийн ажлын алба
3	НҮБХ-ийн Хөтөлбөр	Монгол Улсын төрийн албаны гүйцэтгэл, төрийн үйлчилгээг оролцооны аргаар үнэлэх, хяналт шинжилгээ хийх арга зүйг боловсруулахад бодлогын дэмжлэг үзүүлэх 2005/04/01-2006/07/01		250,000.00	250,000,00					Ц.Самбаллхун дэв
4	Шведийн олон улсын хамтын ажиллагааны агентлаг СИДА	2002-2005 онд ЗГХЭГазар болон Шведийн төрийн захиргааны олон улсын институтын хэрэгжүүлсэн Ардчилсан Монгол дахь сайн засаглал төслийн Манлайллын сургалтын бүрэлдэхүүн хэсэг 2002/09 сараас 2006/03 сар		4,608,935.00 швед к рон 674,353,70 ам доллар	674,353,70					ЗГХЭГ-ын дэд дарга Л.Хангай

5	Шведийн олон улсын хамтын ажиллагааны агентлаг СИДА	Манлайллын сургалтын хөтөлбөр 2006-2009		8,400,000 швед крон 1,228,849,0 ам доллар	358,873,90	569,161,10	207,843,30		92,970,70	Төслийн хэрэгжүүлэх нэгж Л. Золзаяа
6	Дэлхийн банк	Цалингийн сан, орон тооны нөөц хангалтыг бүрдүүлэх замаар төсвийн зарлагын удирдлагыг сайжруулах IDF GRANT No. TF052480 2003/08/01-2006/11/30		312,000,00	242,000,00	8,000,00	31,500,00	30,500,00		Ц.Самбаллхун дэв, Р.Очбадрах
7	Азийн хөгжлийн банк	Төрийн захиргааны шинэтгэлийн төсөл – Төрийн албаны мэдээллийн сүлжээний программ хангамж боловсруулах портал сайт байгуулах 2004-12/01-2005-06/01	400,000,00					302,317,50	97,682,50	Ц.Самбаллхун дэв, Р.Очбадрах, Ч.Мөнхбат
8	Австралийн Олон Улсын хөгжлийн байгууллагын CaBSAF төсөл	Ажлын байрны дүн шинжилгээ ба үнэлгээ болон ажлын түвшний стандартыг боловсруулах төсөл 2005/04/16-2006/01/30		62,495.00 австрали доллар 51,875,10 ам доллар	51,875.10					Ж.Уранбилэг
9	Австралийн ЗГ	“Залуу элч” хөтөлбөр 2006/04/01-2007/04/01								Ц.Самбаллхун дэв, Р.Очбадрах
	<b>Нийт</b>		<b>3,508,560,00</b>	<b>2,902,777.80</b>	<b>3,356,262.70</b>	<b>698,661.10</b>	<b>279,343.30</b>	<b>1,886,417.50</b>	<b>190,653.20</b>	
	<b>Нийт зээл, туламжинд эзлэх хувь</b>		<b>6,411,337.80</b>		<b>52,3</b>	<b>10,9</b>	<b>4,4</b>	<b>29,4</b>	<b>3,0</b>	

## Холбогдох байгууллагын санал



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
АУДИТОР Л.ЖАВЗМАА ТАНАА

МОНГОЛ УЛС  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

211238 Улаанбаатар-12  
Чингэлтэй дүүрэг, Ж.Самбуугийн гудамж 11,  
Утас: 264216, Факс: 264480

2007.06.28 № 208

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Санал хүргүүлэх тухай

Үндэсний аудитын газраас Төрийн албаны зөвлөлийн зарим үйл ажиллагааны үр дүнд хийсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад дор дурдсан саналыг хүргүүлж байна:

**Нэг. Ерөнхий дүгнэлтийн талаар:**

Төрийн албаны тухай хууль (ТАТХ), Төсвийн байгууллагын удирлага, санхүүжилтийн тухай хууль (ТБУСТХ), УИХ-ын 2004 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны стратеги”-ийн баримт бичиг, УИХ-ын 2002 оны 85 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн дүрэм”, “Төсвийн ерөнхийлөн захирагч нарт бүтээгдэхүүний ерөнхий анги хуваарилах тухай” Засгийн газрын 2006 оны 23 дугаар тогтоол, төрийн албаны стандартыг тэдгээртэй нийцүүлэх талаар гаргасан эрх зүйн актуудад заасан бүрэн эрх, чиг үүргийг Төрийн албаны зөвлөл хэрэгжүүлж байна. Тухайлбал:

- Төрийн албаны тухай хуулиар хүлээлгэсэн 14 бүрэн эрх, түүний хүрээнд хэрэгжүүлэх 30 гаруй чиг үүрэг;
- Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн тавдугаар бүлэг, 43-49 дүгээр зүйлүүдэд заасан 47 бүрэн эрх, мөн тэдгээрийн хүрээнд хэрэгжүүлэх 60 гаруй чиг үүрэг, ажил, үйлчилгээ;
- Төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны стратегийн баримт бичигт тодорхойлсон 6 стратегийн хүрээнд 11 стратеги зорилт, хэрэгжүүлэх 9 үүрэг, төрийн байгууллагуудад үзүүлэх 5 төрлийн үйлчилгээ;
- УИХ-ын 2002 оны 85 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн дүрэм”-ийн “Хоёр”-ын 1-18-д заасан 18 эрх, үүрэг;
- Засгийн газрын 2006 оны 23 дугаар тогтоолд заасан Төсвийн ерөнхийлөн захирагчийн нийлүүлэх бүтээгдэхүүний 6 ерөнхий анги, тэдгээрийг нийлүүлэхийн тулд гүйцэтгэх 12 бүтээгдэхүүний анги, 24 бүтээгдэхүүн зэргийг хамарсан өргөн цар хүрээтэй, олон төрлийн, цогц үйл ажиллагааг Монгол Улсын хэмжээнд хэрэгжүүлэх үүргийг гагцхүү Төрийн албаны зөвлөл хүлээж байгаа билээ.

Гэтэл Үндэсний аудитын газраас Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны үр дүнд аудит хийхдээ:

- 1) ТАТХ-ийн 35.1.9-д заасан “мэргэшлийн шалгалтаар иргэнийг төрийн албанд авах...”;

2) Мөн зүйлд заасан "...төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх...";

3) ТАТХ-ийн 35.1.1-д "удирдлагын үндэсний чадавхийг хөгжүүлэх бодлого хэрэгжүүлэх үйл ажиллагааг уялдуулан зохицуулах" гэж заасан бүрэн эрхийн хүрээнд "Төрийн албаны зөвлөлд хэрэгжүүлж байгаа төслүүдийн үр дүн";

4) ТБУСТХ-ийн 45 дугаар зүйл, ТАТХ-ийн 35.1.6, УИХ-ын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам"-д заасны дагуу төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулахад Төрийн албаны зөвлөлийн гүйцэтгэх үүрэг, оролцоо гэсэн 4 төрлийн үйл ажиллагааны хүрээг хамарсан билээ.

Ийнхүү Төрийн албаны зөвлөлийн дөрвөн төрлийн үйл ажиллагаанд аудит хийсэн атлаа "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны үр нөлөө хангалтгүй байна" гэсэн ерөнхий дүгнэлт хийхээр аудитын тайлангийн төсөлд тусгасан нь манай байгууллагын үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг бүхэлд нь харлуулсан, хэт өрөөсгөл, шуларга бус, бодит байдалд нийцэхгүй байна. Иймд уг дүгнэлтийг зөвхөн аудит хийсэн 4 төрлийн үйл ажиллагааны зарим нэгэн менежментийн үр дүн тааруухан байгаа хэсэгт хамааруулан тодотгон тайлбарлаж аудитын тайланд тусгуулахыг санал болгож байна.

**Хоёр. "Бүлэг 1. Төрийн албан хаагчийн мэргэшлийн шалгалтын үр нөлөөг дээшлүүлж, нөөцийн бүртгэлийг боловсронгуй болгох шаардлагатай байна" гэсэн дүгнэлтийн талаар;**

1-р бүлэг, 4 дүгээр хуудасны 8 дахь параграфт:

"1996 оноос хойш төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний мэргэшлийн шалгалтад тэнцсэн 5349 иргэн ажилд орж чадалгүй нөөцийн бүртгэлээс хасагдсан байна" гэжээ.

Төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн болгон нь ажил, албан тушаалд томилогдох үндэс байхгүй юм. Учир нь нэг албан тушаал дээр 1 болон түүнээс дээш хэдэн арван иргэн шалгалт өгч тэнцээд нөөцийн жагсаалтад бүртгэгдэх болзлыг хангадаг боловч зөвхөн 1 иргэн л тухайн зарлагдсан ажлын байранд томилогддог юм. Үүнээс бусад ажилд томилогдоогүй үлдсэн иргэдийг төрийн албанд анх орох иргэний нөөцөд бүртгэж 2 жилийн хугацаанд нөөцдөө байлгаж байгаад хугацаа нь дуусдаг журамтай.

Тухайн албан тушаалд ажиллаж байгаа хүн нь халагдах, чөлөөлөгдөх үед нөөцөөс авах, эсхүл төрийн захиргааны байгууллагууд хүний нөөцийн нөхөн хангалт хийх зорилгоор нөөцөөс авах тохиолдол байдаг.

Иймд иргэд олноороо нөөцийн бүртгэлээс хасагдаж байна гэх ойлголт байж болохгүй гэдгийг анхааралдаа авахыг хүсье.

**Гурав. "Бүлэг 2. Төрийн албан хаагчийн үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх ажлыг орхигдуулсан байна" гэсэн дүгнэлтийн талаар;**

"Төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх ажлыг орхигдуулсан байна" гэсэн дүгнэлт нь үндэслэлгүй дүгнэлт болжээ. Учир нь:

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 47.1-д “Төрийн албаны төв байгууллага нь төсвийн ерөнхийлөн захирагч холбогдох албан тушаалтантай, ерөнхий менежер төсвийн байгууллагын албан хаагчтай байгуулах үр дүнгийн гэрээ, түүнийг дүгнэх заавар, журмыг баталж, биелэлтэд нь хяналт тавина” гэж заасан нь Төрийн албаны зөвлөл заавар, журмаа баталж, түүний биелэлтэд нь хяналт тавина, харин ерөнхий менежер албан хаагчтайгаа үр дүнгийн гэрээ байгуулж, биелэлтийг нь үнэлж дүгнэнэ гэсэн агуулга байгааг төвөггүй ойлгож болно. Өөрөөр хэлбэл, Төрийн албаны зөвлөл нь төрийн албан хаагчийн үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэлж дүгнэдэг эрх бүхий субъект биш юм.

Үүнтэй холбогдуулан Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 48.3-т **“Ерөнхий менежер хүний нөөцийн асуудлаар хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд төрийн албаны төв байгууллага хөндлөнгөөс оролцохыг хориглоно”** гэж заасан байдгийг анхаарахад илүүдэхгүй болов уу.

Төрийн албаны тухай хуулийн 35.1.9 болон Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 47.1-ийг үндэслэн Төрийн албан зөвлөл холбогдох заавар, журам, зөвлөмжийг батлан нийт төрийн албаны хэмжээнд мөрдүүлж байна. Тухайлбал, Төрийн албаны зөвлөлийн 2002 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Ерөнхий менежер төрийн албан хаагчтай үр дүнгийн гэрээ байгуулах заавар”, 2003 оны 07 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшин, төрийн үйлчилгээний албан хаагчийн үр дүнгийн гэрээг үнэлж, дүгнэх журам”, 2004 оны 11 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө боловсруулах үлгэрчилсэн журам”, 2005 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаар сайшаасан “Төрийн албан хаагчийн үр дүнгийн гэрээний биелэлтийн тайлан бичих зөвлөмж”-ийг төрийн болон төсвийн байгууллагууд 3-5 дахь жилдээ мөрдөн ажиллаж байгаа бөгөөд Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүд, Ажлын албаны ажилтнууд дээрх заавар, журмын биелэлтийн байдлыг төв, орон нутгийн төрийн болон төсвийн байгууллагуудад шалгаж, зөвлөгөө өгч ажилладаг юм.

Хэрэв “Төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх ажлыг орхигдуулсан байна” гэж дүгнэвэл Монгол Улсын хэмжээнд төрийн чиг үүргийг хэрэгжүүлж байгаа 5200 орчим төрийн болон төсвийн байгууллагын ерөнхий менежер нар, түүний дотор Аудитын төв, орон нутгийн байгууллагын ерөнхий менежер нар ажилтнуудынхаа үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнэдэггүй гэсэнтэй адил утгатай болно.

Төрийн болон төсвийн байгууллагын ерөнхий менежерүүд төрийн албан хаагчийнхаа үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэлж дүгнэх ажил улсын хэмжээнд хэвшиж байгаа бөгөөд Төрийн албаны зөвлөл энэ талаарх судалгааг жил бүр авч, улсын хэмжээнд нэгтгэн дүн шинжилгээ, дүгнэлт хийж ажилладаг. Төрийн албан хаагчдын 2003-2005 оны үр дүнгийн гэрээний биелэлтийн үнэлгээний нэгдсэн судалгааны материалыг Үндэсний аудитын газрын шалгалтын хүмүүст өгсөн болно.

**Дөрөв. “Бүлэг 3. Төрийн албаны зөвлөлд хэрэгжиж байгаа төслүүдийн үр дүн, түүний гүйцэтгэлд хяналт тавих ажил хангалтгүй байна” гэсэн дүгнэлтийн талаар:**

“...Төрийн албаны зөвлөлд хэрэгжиж байгаа төслүүдийн үр дүн ... хангалтгүй байна” гэсэн дүгнэлт нь бодит байдалд нийцээгүй өрөөсгөл дүгнэлт болсон гэж үзэж байна.


Монгол Улсын хууль(2003.11.13-ны өдөр)-иар соёрхон баталсан Монгол Улс, Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциацийн хооронд “**Эдийн засгийн чадавхийг бэхжүүлэх техник туслалцааны зээлийн төсөл**”-ийг хэрэгжүүлэх тухай Хөгжлийн зээлийн гэрээний хүрээнд Төрийн албаны зөвлөл дээр хэрэгжсэн буюу одоо хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээ, мөн түүнчлэн Шведийн Засгийн газар, НҮБХХ-тэй хамтран хэрэгжүүлсэн болон одоо хэрэгжүүлж буй бусад төсөл, арга хэмжээ нь Монгол Улсын Төрийн захиргааны шинэтгэлийг гүнзгийрүүлэх, Төрийн албаны тухай хууль, Төсвийн байгууллагын удирлага, санхүүжилтийн тухай хуулиар Төрийн албаны зөвлөлд ногдуулсан бүрэн эрх, чиг үүрэг, ялангуяа УИХ-ын 2004 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “**Монгол Улсын Төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны стратеги**”-ийн баримт бичигт тодорхойлсон төрийн албаны бодлого, стратегийг хэрэгжүүлэхэд чухал түлхэц болж байгаа билээ.

Иймд аудитын тайлангийн төслийн 3-р бүлгийн дүгнэлтийн “... **Төрийн албаны зөвлөлд хэрэгжиж байгаа төслүүдийн үр дүн ... хангалтгүй байна**” гэсэн хэсгийг болон уг тайлангийн 10-р хуудасны эхний абзацад дурдсан “**Төсөл, хөтөлбөрүүдийн зорилтын биелэлт, үр дүн ... хангалтгүй**” гэсэн хэсгийг тус тус хөтөлбөр, төслүүдийн зорилтын бодит биелэлт, гүйцэтгэлтэй харьцуулан нягтлан авч үзэхийг санал болгож байна.

Тэрчлэн хандивлагч орон, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн санхүүжилтийн эх үүсвэрээс хууль бусаар ашигласан, эсэхтэй холбогдсон зөрчил байгаа, эсэх талаар аудитын тайланд тусгаж манай байгууллагаас цаашид үйл ажиллагаагаа хэвийн явуулахад гүн туслалцаа үзүүлэхийг хүсье.

Аудитын тайлангийн төсөлтэй танилцаад хүргүүлж байгаа эдгээр саналыг тайланг эцэслэн гаргахдаа анхаарч үзэхийг хүсье.



 Ж.НОРОВСАМБУУ

## ТАЗ-ийн саналд өгөх тайлбар

### **Тайлбар 1**

Төрийн албаны зөвлөлөөс ирүүлсэн саналыг судлан “Төрийн албаны зөвлөлийн зарим үйл ажиллагааны үр нөлөөг сайжруулах шаардлагатай байна” гэж дүгнэлт өгөх нь зүйтэй гэж үзлээ.

### **Тайлбар 2**

Төрийн албаны шалгалт өгч тэнцээд нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн иргэдээс 5 мянга гаруй иргэн төрийн албанд томилогдоогүй нөөцийн бүртгэлээс хасагдсан нь бодит байдал, нөөцийн жагсаалтад бүртгэгдэх, нөөцөөс төрийн албанд томилох журам, болзлыг боловсронгуй болгох шаардлагатай талаар аудитын тайланд тусгасан.

### **Тайлбар 3**

Аудитаар төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшин, үр дүнг үнэлж дүгнэх ажил хангалтгүй гэж үзсэн ба аудитын тайланд өгсөн танай саналд үндэслэн “Төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх ажлыг орхигдуулсан байна” гэсэн дүгнэлтийг “.....үнэлж дүгнэх ажлын биелэлтэд тавих хяналтыг орхигдуулсан байна” гэж өөрчлөн тайланд тусгав.

### **Тайлбар 4**

ТАЗ-д хэрэгжсэн төслүүдийн үр дүнгийн талаархи дүгнэлтийг аудитын явцад цуглуулсан холбогдох баримтуудад тулгуурлан гаргасан тул үндэслэлтэй гэж үзэж байна.

## Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухайн хуулийн 13.4.5, "Гүйцэтгэлийн шалгалтын журам"-ын 23 дугаар зүйлийн 2, "Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам"-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Төрийн албаны зөвлөлийн 2005-2006 оны зарим үйл ажиллагааны үр дүнд хийсэн аудитын тайланг баталсугай.

Хоёр. Аудитын тайланг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын Байнгын хороонд болон Төрийн албаны зөвлөлийн дарга Ж.Норовсамбууд хүргүүлсүгэй.

Гурав. Аудитын тайлангаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2007 оны 12 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт танилцуулахыг Төрийн албаны зөвлөлийн дарга Ж.Норовсамбууд зөвлөсүгэй.

Дөрөв. Аудитын зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг нэгдүгээр газрын захирал Д.Ганбилэгт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР

Л.ЖАВЗМАА